

**ТӨСВИЙН ЕРӨНХИЙЛӨН ЗАХИРАГЧ #
НАРЫН 2023 ОНЫ ХУДАЛДАН АВАХ #
АЖИЛЛАГААНЫ ХЭРЭГЖИЛТИЙН ТАЙЛАН**

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль /цаашид “хууль” гэх/-ийн 46 дугаар зүйлийн 46.3 дахь хэсэг, Сангийн сайдын 2023 оны А/250 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааг төлөвлөх, тайлагнах журам”-ын 3 дугаар зүйлд заасны дагуу төсвийн ерөнхийлөн захирагч нарын 2023 оны худалдан авах ажиллагааны хэрэгжилтийг худалдан авах ажиллагааны цахим систем (www.tender.gov.mn)-д /цаашид “цахим систем” гэх/ нийтэлсэн төлөвлөгөө, түүний биелэлт, үр дүн болон гомдлын судалгаанд үндэслэн мөн журмын 4 дүгээр зүйлд зааснаар хяналт тавьж, дүн шинжилгээ хийлээ.

Хуулийн 46 дугаар зүйлийн 46.2 дахь хэсэгт зааснаар нийт 60 төсвийн ерөнхийлөн захирагчаас 54 төсвийн ерөнхийлөн захирагч 2023 оны худалдан авах ажиллагааны хэрэгжилтийн тайланг цахим системээр ирүүлсэн. Боомтын сэргэлтийн үндэсний хорооны дарга, Нийслэл Улаанбаатар хотын автозамын түгжрэлийг бууруулах үндэсний хорооны дарга, Улсын Их Хурлын дарга, Үндсэн хуулийн цэцийн дарга, Хүний эрхийн үндэсний комиссын дарга, Цагаатгах ажлыг удирдан зохион байгуулах улсын комиссын дарга нар худалдан авах ажиллагааны 2023 оны хэрэгжилтийн тайлан ирүүлээгүй байна.

• **Худалдан авах ажиллагааны төлөвлөлт**

Цахим системээр ирүүлсэн төсвийн ерөнхийлөн захирагч нарын худалдан авах ажиллагааны 2023 оны тайлангаас үзэхэд нийт 14,904.6 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй 32,893 төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг зохион байгуулахаар төлөвлөсөн байна. Энэ нь өмнөх онтой харьцуулахад төсөвт өртгийн хувьд 2 хувиар, тоо хэмжээний хувьд 7 хувиар өссөн үзүүлэлттэй байна. (хүснэгт 1.)

Хүснэгт 1. Худалдан авах ажиллагааны төлөвлөлт

Тендер шалгаруулалтын аргын нэр	Тендер шалгаруулалтын тоо		Төсөвт өртөг /тэрбум төгрөг/		Харьцуулалт	
	2022	2023	2022	2023	ТШ-ын тоо	Төсөвт өртөг
Нээлттэй тендер шалгаруулалтын журам	7,494	8,015	11,814.9	13,254.9	↑ 7%	↑ 11%
Тендер шалгаруулалтын онцгой журам	8,952	8,127	2,277.6	1,121.3	↓ -10%	↓ -103%
Зөвлөх үйлчилгээний гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах журам	1,234	1,114	395.4	376.6	↓ -11%	↓ -5%
Шууд худалдан авалт	12,751	15,512	122.7	150.2	↑ 18%	↑ 18%
Олон нийтийн оролцоотой худалдан авах ажиллагааны журам	128	125	1.5	1.6	↓ -2%	↑ 6%
Нийт	30,559	32,893	14,611.90	14,904.63	↑ 7%	↑ 2%

Худалдан авах ажиллагааны төлөвлөлтийг дээрх хүснэгтээс харахад нийт 13,254.9 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй 8,015 төсөл, арга хэмжээг нээлттэй тендер шалгаруулалтын журмаар, 1,121.3 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй 8,126

төсөл, арга хэмжээг онцгой журмаар, 376.6 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй 1,114 төсөл, арга хэмжээг зөвлөх үйлчилгээний гүйцэтгэгчийг сонгох журмаар, 150.2 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй 15,512 төсөл, арга хэмжээг шууд худалдан авалтаар, 1.6 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй 125 тендер шалгаруулалтыг олон нийтийн оролцоотой худалдан авах ажиллагааны журмаар тус тус зохион байгуулахаар төлөвлөсөн байна. Үүнийг төсөвт өртгөөр авч үзвэл нийт 13,254.9 тэрбум төгрөг буюу нийт төсөвт өртгийн 90 орчим хувь нь нээлттэй тендер шалгаруулалтын журмаар зохион байгуулахаар төлөвлөсөн нь ил тод, нээлттэй байх хуулийн зарчимд нийцсэн байна.

Харин төсөл, арга хэмжээний тоогоор хамгийн олон төсөл, арга хэмжээ төлөвлөсөн нь шууд худалдан авалт байх бөгөөд 15,512 төсөл, арга хэмжээ байна. Үүнийг төсөвт өртгөөр нь харвал нийт 150.2 тэрбум төгрөг буюу нийт төсөвт өртгийн 9 орчим хувийг эзэлж байх бөгөөд өмнөх онтой харьцуулахад 18 хувиар өссөн үзүүлэлттэй байна.

Шууд худалдан авч болох төсөвт өртгийн хэмжээг 10.0 сая төгрөг байсныг 2021 оноос эхлэн 20.0 сая төгрөг болгон нэмэгдүүлж өөрчилсөн. Сүүлийн жилүүдэд шууд худалдан авалтаар бараа, ажил, үйлчилгээ худалдан авахаар төсөв баталж байгаа байдал жилээс жилд нэмэгдэж байна.

- **Худалдан авах ажиллагааны хэрэгжилт**




График 1. Тендер шалгаруулалтын зарласан байдал

2005 онд батлагдсан Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1 дэх хэсэгт заасан босго үнээс дээш төсөвт өртөг бүхий цахим системээр зохион байгуулах нийт 14,754.4 тэрбум төгрөгийн төсөвт өртөг бүхий 17,381 тендер шалгаруулалт байна. Тайлант хугацаанд 1,788 захиалагч 12,147.6 тэрбум төгрөгийн төсөвт өртөг бүхий 13,505 тендер шалгаруулалт зохион байгуулсан, 3,877 төсөл, арга хэмжээ буюу тендер шалгаруулалтын 22 орчим хувийг зохион байгуулаагүй байна. Энэ нь 2022 онтой харьцуулахад 8 хувиар буурсан хэдий ч захиалагч худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг үндэслэлтэй боловсруулах, төлөвлөсөн төсөл, арга хэмжээг заасан хугацаандаа бүрэн зохион байгуулах шаардлагатай гэж дүгнэж байна.

Тайлант хугацаанд нийт 12,147.6 тэрбум төгрөгийн төсөвт өртөг бүхий 13,505 тендер шалгаруулалт зарласныг санхүүжилтийн эх үүсвэрээр ангилан үзвэл өөрийн хөрөнгөөр 73 хувь буюу 8,817.11 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй 5,601, улсын төсвийн хөрөнгөөр 12 хувь буюу 1,481.71 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй 2,528, орон нутгийн төсвийн хөрөнгөөр 12 хувь буюу 1,441.27 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй 4,800, сан болон бусад эх үүсвэрээр 2 хувь буюу 266.12 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй 467, зээл тусламжийн хөрөнгөөр 1 хувь буюу 141.33 тэрбум

төгрөгийн төсөвт өртөгтэй 109 тендер шалгаруулалтыг тус тус зарласан байна (график 2).

#




График 2. Төсөвт өртөг (Санхүүжилтийн эх үүсвэрээр 2023 он)

#

#




График 3. Төсөвт өртөг (Санхүүжилтийн эх үүсвэр 2022 он)

Худалдан авах ажиллагааны 2023 оны тайланг санхүүжилтийн эх үүсвэрээр 2022 оны тайлантай харьцуулахад 2023 онд өөрийн хөрөнгөөр худалдан авсан бараа, ажил, үйлчилгээний төсөв 2 дахин нэмэгдсэн бол улсын төсвийн хөрөнгөөр худалдан авсан төсөл, арга хэмжээ 3 дахин буурсан байна. Улсын төсвийн хөрөнгийн санхүүжилтийн дүн буурсан нь 2023 оны төсвийн тухай хуулийн 2 дугаар хавсралтаар батлагдсан улсын төсвийн хөрөнгө оруулалтаар санхүүжүүлэх шинээр эхлэх төсөл, арга хэмжээ, барилга байгууламж өмнөх оноос бага байсантай холбоотой байна (хүснэгт 2).

Хүснэгт 2. Төсөвт өртөг (Санхүүжилтийн эх үүсвэрээр)

Санхүүжилтийн эх үүсвэр	Төсөвт өртөг /тэрбум төгрөг/	
	2022 он	2023 он
Өөрийн хөрөнгө	4,776.49	8,817.11
Улсын төсөв	3,752.34	1,481.71
Орон нутгийн төсөв	1,342.55	1,441.27
Сан болон бусад	122.22	266.12
Зээл, тусламж	56.01	141.33
Нийт	10,049.60	12,147.55

Тайлант хугацаанд нийт 8,817.11 тэрбум төгрөгийн төсөвт өртөг бүхий 5,601 тендер шалгаруулалтыг төрийн болон орон нутгийн өмчийн хуулийн этгээд, төсөвт байгууллагууд зохион байгуулсан ба өнгөрсөн оноос төсөвт өртөг хоёр дахин нэмэгдсэн үзүүлэлттэй байна. Өөрийн хөрөнгөөр санхүүжих төсөл, арга хэмжээний 7,355.2 тэрбум төгрөг буюу 80 гаруй хувь нь “Эрдэнэс тавантолгой” ХК, “Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ, Монгол-Оросын хувь нийлүүлсэн нийгэмлэг “Улаанбаатар төмөр зам”, “Тавантолгой” ХК, “Багануур” ХК, “Дарханы төмөрлөгийн үйлдвэр” ТӨХК, “Тавантолгой түлш” ХХК, “Монголросцветмет” ТӨҮГ-уудын худалдан авах ажиллагаа байна. Тодруулбал, 2023 онд “Эрдэнэс тавантолгой” ХК 4,146.2 тэрбум төгрөг, “Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ 1,633.3 тэрбум төгрөг, “Улаанбаатар төм зам” ХНН 638.7 тэрбум төгрөгийн төсөвт өртөг бүхий худалдан авах ажиллагааг тус тус зохион байгуулсан байна.

“Эрдэнэс тавантолгой” ХК-аас зарласан Цанхийн баруун уурхайн хөрс хуулалт, олборлолтын ажил, Цанхийн зүүн уурхайн хөрс хуулалт, нүүрс олборлолт (Багц 1), Цанхийн баруун уурхайн хөрс хуулалт, нүүрс олборлолт (Багц 3), Цанхийн баруун уурхайн тэсэлгээ зэрэг өндөр төсөвт өртөгтэй тендер шалгаруулалт нь өөрийн хөрөнгийн санхүүжилтийн төсөвт өртгийн хэмжээ өмнөх оноос хоёр дахин өсөхөд нөлөөлсөн байна.

- **Худалдан авах ажиллагааны цахим системээр тендер шалгаруулалт зохион байгуулсан байдал:**

2005 оны Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.4 дэх хэсэгт захиалагч тендер шалгаруулалт бүрийн урилга, үр дүнг цахим системд тухай бүр зарлахаар хуульчилсан.

Тайлант хугацаанд 209 тендер шалгаруулалтыг уламжлалт хэлбэрээр зохион байгуулахаар зарласан нь нийт тендер шалгаруулалтын 1 хувьд хүрэхгүй үзүүлэлт боловч 2022 онтой харьцуулахад 30 орчим хувь өссөн нь худалдан авах ажиллагааны ил тод, нээлттэй, өрсөлдөх тэгш боломжтой байх хуулийн үндсэн зарчимд нийцэхгүй байна.

2023 онд нээлттэй тендер шалгаруулалтын 52 хувь, тендер шалгаруулалтын онцгой журмаар зарласан тендер шалгаруулалтын 27 хувь дахин зарлагдсан байна.

Нээлттэй тендер шалгаруулалтын журмаар зарласан тендер шалгаруулалт амжилтгүй болсон шалтгаан нь нэг талаас оролцогчгүй байх, ирүүлсэн тендерүүд шаардлагад нийцэхгүй байх, нөгөө талаас захиалагч тендер шалгаруулалтын баримт бичгийн шаардлага, шалгуур үзүүлэлтийг хэт өндөр боловсруулсантай холбоотой байгаа тул цаашид тендер шалгаруулалтыг амжилттай зохион байгуулахад анхаарах шаардлагатай байна.

Сангийн сайдын 2019 оны 255 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан “Худалдан авах ажиллагааны цахим системээр тендер шалгаруулалт зохион байгуулах, холбогдох мэдээллийг зарлан мэдээлэх журам”-ын 3.2.7-д зааснаар захиалагч цахим системд тендер шалгаруулалтын үр дүнг үнэн зөв, бүрэн нийтлэх үүрэгтэй байдаг бөгөөд тухайн үр дүн нийтэлсэн өдөр шалгарсан оролцогчийн нууцлаагүй хэсгийг бусад оролцогчдод ил болгодог.




График 4. Тендер шалгаруулалт зарласан байдал

Цахим системд нийтэлсэн урилга, үр дүнгийн мэдээлэл (график 3)-ээс үзэхэд 2023 онд 13,505 тендер шалгаруулалтын давхардсан тоогоор 23,141 урилга нийтэлсэнээс 22,232 үр дүн буюу 96 хувийг цахим системд нийтэлж, шалгарсан оролцогчийн тендерийг бусад оролцогчдод ил болгосон байна. Үр дүнгийн 4 хувь нь тендер шалгаруулалт амжилтгүй болж дахин зарлагдсантай холбоотой байна.

Худалдан авах ажиллагааны цахим системд гэрээний мэдээлэл оруулсан байдал:

2005 оны Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1.6 дахь заалтад зааснаар захиалагч гүйцэтгэгчийн гэрээний үүргийн биелэлтэд чанар болон гүйцэтгэлийн хяналт тавьж, явцын мэдээллийг хагас жил тутам цахим системд оруулах үүрэгтэй.

Цахим системд бүртгэлтэй 22,059 аж ахуй эрхлэгч бүртгэлтэй байна. 2023 онд цахим системд нийт 13,505 тендер шалгаруулалт зарлагдсан ба захиалагч байгууллагууд 10,229 тендер шалгаруулалтын үр дүнд давхардсан тоогоор 13,559 гэрээ байгуулсан мэдээлэл цахим системд оруулсан байна. Харин үүнийг гэрээний

нийт төсөвт өртөгөөр авч үзвэл цахим системд нийтэлсэн гэрээ нь 5,431.1 тэрбум төгрөгийн үнийн дүнтэй байгаа нь нийт худалдан авах ажиллагааны төсөвт өртөг (12,147.6 тэрбум төгрөг)-ийн 44 хувь байна.

Үүнээс дүгнэвэл 2023 онд захиалагч тендер шалгаруулалтын үр дүнд байгуулсан гэрээний 56 хувийг цахим системд байршуулаагүй нь Сангийн сайдын 2021 оны 242 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан “Худалдан авах ажиллагааны цахим системээр тендер шалгаруулалт зохион байгуулах, холбогдох мэдээллийг зарлан мэдээлэх журам”-ын 8.5-д “Захиалагч, гүйцэтгэгчийн хооронд байгуулах бараа, ажил, үйлчилгээ худалдан авах гэрээний хувийг захиалагч гэрээ байгуулсан даруйд цахим системд байршуулна” гэж заасныг хэрэгжүүлээгүй байна.

• Гэрээ байгуулах эрх олгосон асуудлаар гарсан гомдлын шийдвэрлэгдсэн байдал:

Хуулиар оролцогчоос тендер шалгаруулалттай холбоотой гомдлыг гаргахад аль шатанд ямар байгууллагад хандахыг тодорхой зааж өгсөн байдаг. #

Төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь гэрээ байгуулах эрх олгосноос хойш ажлын 5 өдрийн дотор тендерт оролцогч нараас ирүүлсэн гомдлыг хүлээн авч 14 хоногт хянан шийдвэрлэдэг. Сангийн яаманд 1019 аж ахуйн нэгж, байгууллага, иргэдээс давхардсан тоогоор 2057 гомдол гаргасан.

Үүнээс, хуульд заасан захиалагчийн гэрээ байгуулах шийдвэрт хамаарах 1,486 гомдлыг хянан шийдвэрлэхэд захиалагчийн шийдвэр үндэслэлтэй 26 хувь буюу 392, захиалагчийн шийдвэр үндэслэлгүй гэсэн шийдвэр 1,094 буюу 74 хувийг эзэлж байна. Гомдол шийдвэрлэгдсэн байдлыг 2022 онтой харьцуулахад захиалагчийн шийдвэр үндэслэлгүй гомдол 12 хувиар өссөн байна.

Энэ нь үнэлгээний хорооны гишүүд тендер шалгаруулалтын үнэлгээг хийхдээ зохих хууль тогтоомжийг мөрдлөг болгон ажиллаагүй, нөгөө талаас захиалагч 2005 оны Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1.2 дахь заалтын биелэлт хангалтгүй, үнэлгээний хорооны үйл ажиллагаа, үнэлгээний дүгнэлт хуульд нийцсэн эсэхэд хяналт тавьж, гарсан зөрчлийг арилгуулах үүргээ хангалтгүй хэрэгжүүлж байгаатай холбоотой байна. #

Нөгөөтээгүүр Сангийн яаманд оролцогч үндэслэл бүхий гомдол гаргах хуулийн зохицуулалттай ба 2023 онд нийт 125 гомдлыг бүхэлд нь үндэслэлгүй гэж шийдвэрлэж, нийт 631,776,000.00 төгрөгийн үнийн дүнтэй тендерийн баталгааг улсын орлого болгон Төрийн сангийн 100900000753 тоот “Тендерийн баталгааны орлого” дансанд төвлөрүүлсэн байна.

Тендерт оролцогчоос захиалагчийн шийдвэрт гаргасан гомдлын 74 хувь нь үндэслэлтэй гэж шийдвэрлэгдсэн байгаа нь тендер шалгаруулалттай холбоотой захиалагчийн хууль бус шийдвэрийг хуульд нийцүүлэх шийдвэрийг Сангийн яам гаргасан байна.

Үүнээс дүгнэхэд захиалагчийн худалдан авах ажиллагаанд оролцож буй ажилтан, албан тушаалтнуудыг мэргэшсэн байдлыг сайжруулах шаардлагатай бөгөөд буруутай этгээдэд холбогдох хууль тогтоомжийн дагуу хариуцлага тооцдог байх хэрэгтэй байна.

- **Худалдан авах ажиллагааны сургалтын талаар:**

Улсын Их Хурлын 2023 оны 06 дугаар сарын 16-ны өдрийн чуулганы нэгдсэн хуралдаанаар Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийн төслийг хэлэлцэн баталж, хууль 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөхтэй холбогдуулан хуулийг хэрэгжүүлэх бэлтгэл ажлыг хангах зорилгоор захиалагч байгууллагуудад зориулан худалдан авах ажиллагааны хууль, журмыг танилцуулах сургалтыг үе шаттайгаар зохион байгуулсан. #

2023 онд хуулийн шинэчилсэн найруулгын талаарх сургалт авах хүсэлт ирүүлсэн 13 байгууллагын 800 орчим албан хаагч нарт танилцуулга, мэдээлэл хүргэсэн.

Хуулийн 53 дугаар зүйлийн 53.3 дахь хэсэгт “Худалдан авах ажиллагааны мэргэшүүлэх сургалт эрхлэх байгууллага, түүний багш, ажилтанд тавигдах шаардлага, мэргэшүүлэх сургалтын хөтөлбөр, шалгалтын журмыг санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага батална.” гэж заасны дагуу Сангийн сайдын 2023 оны А/251 дүгээр тушаалын хавсралтаар “Худалдан авах ажиллагааны мэргэшүүлэх сургалт эрхлэх байгууллага, түүний багш, ажилтанд тавигдах шаардлага, мэргэшүүлэх сургалтын хөтөлбөр, шалгалтын журам” батлагдсан. #

Хуулийн хэрэгжилтийг хангахад дэмжлэг үзүүлэх, худалдан авах ажиллагааны мэргэшсэн ажилтан болон үнэлгээний хороонд хөндлөнгийн хяналтын үүрэгтэй оролцох иргэдийг бэлтгэх, мөн орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр худалдан авах ажиллагааг зохион байгуулдаг мэргэжилтнүүдийг чадавхжуулах зорилгоор 2023 онд 21 аймагт худалдан авах ажиллагааны мэргэшсэн ажилтан бэлтгэх сургалтыг үе шаттайгаар зохион байгуулж, нийт 1719 суралцагчид худалдан авах ажиллагааны мэргэшсэн ажилтны гэрчилгээг хугацаагүйгээр олгосон.

- **Тендер шалгаруулалтад оролцох эрхээ хязгаарлуулсан этгээдийн бүртгэлийн талаар:**

2005 оны Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулиар тендерт оролцохдоо илт худал мэдээлэл ирүүлсэн, сүүлийн гурван жилийн хугацаанд гэрээний үүргээ ноцтой зөрчсөн, биелүүлээгүй, мэргэжлийн үйл ажиллагаанд алдаа гаргасныг шүүх, байцаагч тогтоосон тохиолдолд оролцогчийг тендерт оролцох эрхээ хязгаарлуулсан этгээдийн бүртгэлд хамруулах үндэслэл болдог.

Төсвийн ерөнхийлөн захирагч, захиалагч аж ахуйн нэгж байгууллага, иргэдээс ирүүлсэн гомдол мэдээлэлд үндэслэн 2023 онд Сангийн яамны Төрийн нарийн бичгийн дарга бөгөөд Худалдан авах ажиллагааны улсын ерөнхий байцаагчийн баталсан 3 удаагийн удирдамжаар нийт 133 хуулийн этгээдийг хамруулан хянан шалгалтыг хийж гүйцэтгэсэн бөгөөд үүнээс 75 хуулийн этгээдийг Сангийн сайдын 3 удаагийн тушаалаар тендер шалгаруулалтад оролцох эрхийг хязгаарлаж, олон нийтэд мэдээлж ажиллалаа.

#

#

• **Төсвийн ерөнхийлөн захирагчдын тайланд өгсөн нэгдсэн дүгнэлт:** #

#

Төсвийн ерөнхийлөн захирагч нарын 2023 оны худалдан авах ажиллагааны хэрэгжилтэд дараах дүгнэлтийг хүргүүлж байна. Үүнд: #

#

1.Цахим системд 2023 онд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн нийт худалдан авах ажиллагааны 20 хувь буюу 5,210 төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг зохион байгуулаагүй, нийт төлөвлөсөн худалдан авах ажиллагааны 9,696 буюу 77 хувь нь төлөвлөсөн хугацаандаа эхлээгүй байгаа нь худалдан авах ажиллагааны төлөвлөлт бодитой бус, төлөвлөгөөнд заасан хугацааг мөрдөж ажиллаагүй, тухайн онд хэрэгжихгүй төсөл, арга хэмжээг олноор төлөвлөж байгаа нь худалдан авах ажиллагаа хэрэгжүүлэхэд хугацаа алдах, төлөвлөлт, гүйцэтгэл зөрөх үндсэн шалтгаан болж байна; #

#

2. Цахим системд 2022 онд 24,573 тендер шалгаруулалтын урилгыг нийтэлснээс 23,457 тендер шалгаруулалтын үр дүн нийтэлсэн ба 2005 оны Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.4 дэх хэсгийг зөрчиж тендер шалгаруулалтын үр дүнг олон нийтэд нийтлэхгүй байх, хугацаа хоцроох буюу жилийн төгсгөлд мэдээлж байна; #

#

3. Шууд худалдан авч болох төсөвт өртгийн дээд хязгаарыг 10.0 сая төгрөг байсныг 20.0 сая төгрөг гэж 2021 онд тогтоосон бөгөөд сүүлийн жилүүдэд захиалагч нар төсөв батлахдаа шууд худалдан авалтын босго үнэд багтаан жижиглэн баталж байгаагаас шууд худалдан авалтын тоо хэмжээ, төсөвт өртөг жилээс жилд өсөж байгаа тул тухайн төсөл, арга хэмжээний үр ашигт илүү анхаарал хандуулах;

4.Сангийн яаманд ирсэн гомдлын дийлэнх буюу 74 хувь нь захиалагч хууль зөрчсөн шийдвэр гаргасан гэсэн хариу гарч байгаагаас дүгнэхэд үнэлгээний хороо тендер шалгаруулалтын үнэлгээг хийхдээ хууль, журмыг зөрчсөн, үндэслэлгүй зөвлөмж гаргах, түүнд захиалагчийн зүгээс хяналт тавихгүй байгаа нь захиалагч 2005 оны Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1.2 дахь заалтын биелэлт хангалтгүй;

5.Улирлын чанартай төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг төлөвлөгөөнд заасан хугацаандаа зохион байгуулахгүй байгаа нийтлэг зөрчил нь 2005 оны Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1.8 дахь заалттай нийцэхгүй байгааг анхаарч ажиллах шаардлагатай байна. #

#